



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Гадаад улсад байгаа иргэдээс
санал авах өдрийг тогтоох тухай


Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 8 дугаар зүйлийн 8.3, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоол, Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Төв комиссын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдээс санал авах ажиллагааг 2021 оны 5 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд явуулахаар тогтоосугай.

2.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төв комисс /Н.Анхбаяр/-г даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000012